

ЗЭСИЙН БАЯЖМАЛ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	
1. Төслийн нэр, хүчин чадал:	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр. Жилд 120 мянган тонн катодын зэс үйлдвэрлэнэ.
2. Төсөл хэрэгжих салбар, дэд салбар:	Хүнд үйлдвэрийн салбар. Өнгөт төмөрлөг боловсруулах үйлдвэрлэл
3. Төслийн хэрэгжих хугацаа:	2016-2019 он
4. Төслийн хөрөнгө оруулалт /сая ам.доллар/:	798,8
5. Хэрэгжүүлэгч яам, байгууллага:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ	
6. Байршил:	<u>Байршил:</u> Хэнтий аймаг, Бор өндөр сум
7. Бүтээгдэхүүн:	Төслийн хүрээнд жилд 530.0 мянган тн. зэсийн баяжмалыг боловсруулж 120 мян.тн катодын зэс, 200 мян.тн хүхрийн хүчил, 110мян.тн элементийн хүхэр тус тус үйлдвэрлэнэ.
8. Төслийн үндэслэл:	<p>-Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсад зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулахаар шийдвэрлэсэн.</p> <p>-Улсын Их Хурлын “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай” 2015 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 10.4 дэх заалтад Зэс хайлуулах үйлдвэрийг барьж байгуулахад шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэхээр тусгасан.</p> <p>-Монгол улсын Засгийн газрын “Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай” 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 247 дугаар тогтоол.</p> <p>-Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.</p>
9. Төслийн зорилго:	Монгол Улсын зэсийн нөөцөд тулгуурлан цэвэр зэс үйлдвэрлэх, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавихад төслийн үндсэн зорилго оршино.
10. Төслийн техникийн баримт бичиг боловсруулсан байдал:	Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн Техник-эдийн засгийн үндэслэлийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төслийн институт /ENFI/ боловсруулж, 2015 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн Аж үйлдвэрийн яамны шинжлэх, технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, дэмжигдсэн.

<p>11. Хүрэх үр дүн:</p>	<ul style="list-style-type: none">-Монгол улс дотооддоо үйлдвэрлэсэн зэс, түүгээр хийсэн бүтээгдэхүүнээр өөрийгөө бүрэн хангаж, эцсийн бүтээгдэхүүн экспортлогч орон болно.- Тухайн үйлдвэрийг дагалдан туслах үйлдвэрүүд, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч жижиг, дунд үйлдвэрлэл хөгжинө.-Үйлдвэрлэлд байгаль орчин, нийгэмд аюулгүй техник, технологи нэвтэрнэ.-Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрээс техник технологи, ажлын байр, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны стандартуудыг эзэмшсэн, дотоод, гадаадын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхүйц дадлага туршлагатай ажиллах хүчин бий болно.-Их дээд сургууль болон техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөр шинэчлэгдэж, шинэ төрлийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо бүрдэнэ.-Экспортын болон импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг шинээр бий болгосноор манай улсын гадаад худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлнэ.-Орон нутагт 759 шууд ажлын байр шинээр бий болгоно.
--------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------